

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САНГИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдөр
Хурал хуралдсан газар: Сангийн яамны хурлын танхим

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан /Монголын МСС/-ийн Удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар дор дурьдсан 6 асуудалтай танилцаж хэлэлцэн харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

Нэгдүгээр асуудал. “Монголын Мянганы сорилтын сан” УТҮГ-ын дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлав.

Хоёрдугаар асуудал. Монголын МСС-ийн ажилтнуудын цалингийн тохируулга, цалингийн шатлалын өөрчлөлт болон 2022 оны ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн нэмэгдлийг батлав.

Гуравдугаар асуудал. МСК-д гаргаж өгөх Зарцуулалтын хүсэлтийг батлах эрхийг Монголын МСС-ийн Гүйцэтгэх захиралд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэв.

Дөрөвдүгээр асуудал. Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн явц, учирч буй эрсдэл болон түүнийг бууруулах арга хэмжээний талаар танилцуулав.

Тавдугаар асуудал. Хаягдал ус дахин боловсруулах төслийн явцын талаар танилцуулав.

Зургаадугаар асуудал. Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн явцын талаар танилцуулав.